

The background is a dark blue gradient. In the center, there is white text. Surrounding the text are various illustrations: hands holding documents with charts, a hand holding a pen over a document, a hand holding a tablet, a hand holding a smartphone, a hand typing on a laptop, a coffee cup, and a pencil. The overall theme is professional work and data analysis.

# МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ШИЙДВЭРЛЭЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Н.Жавхлан  
Г.Отгонжаргал

# Агуулга

1

Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт

2

Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт

3

Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

4

Дүгнэлт, санал

Мөнгө угаах гэмт хэргийн үүсэл



Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт



Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан



түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн



түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан

# Онцлог



1

Эдийн засаг, нийгэм, улс төр гэсэн үндсэн 3 харилцаанд хамгийн их хор хохирол учруулдаг гэмт хэрэг



Биет хохирогчгүй /victimless/ байдаг.

2

3

Хор хохирол нь шууд бус /indirect/ байна. Энэ хүрээнд негатив болон позитив 25 хор хохирлыг тодорхойлдог. Банк санхүү, хөрөнгө оруулалт, худалдаа үйлчилгээ, үнэт цаас буюу эдийн засаг, нийгмийн салбар, улс төр дэх үр дагаврууд байна.

4


Хохирлын хэмжээ нь бодитоор тодорхойлогддоггүй



**Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн  
зохицуулалт**

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц”
- “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын конвенц”
- “Авилгын эсрэг НҮБ-ын конвенц”
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ын нэмэлт болох “Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийгтэх тухай протокол”
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ын нэмэлт болох “Галт зэвсэг, түүний бүрдэл хэсэг, эд анги болон галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протокол”
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ын нэмэлт болох “Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол”

Аливаа улс орон олон  
улсын байгууллага,  
конвенцуудад олноор  
нэгдэн орохоос  
илүүтэй



Тэдгээрийн үнэт зүйл,  
дүрэм журмыг  
баримтлан үндэсний  
хууль тогтоомждоо  
хэрхэн нийцүүлж,  
хэрэглэх асуудал нь  
хамгийн чухал



Иймээс манай улс дээрх хэм хэмжээгээр хүлээсэн үүрэг, арга хэмжээ, олон улсын стандарт, зөвлөмжийг баримтлан:





2022

2019

2013

ФАТФ-ын  
саарал  
жагсаалт

ФАТФ-ын  
саарал  
жагсаалт

Олон улсын Базелийн хорооноос жил бүр гаргадаг дэлхийн мөнгө угаах эрсдлийн 2022 оны үнэлгээгээр 128 орноос 36-т, Зүүн Ази Номхон далайн орнуудад 7-т жагссан.

## Мөнгө угаах гэмт хэргийн хор уршиг



Мөнгө угаах гэмт хэрэг нь дангаараа улс орны санхүүгийн системийг алдагдуулах зэрэг нийгэм, эдийн засагт үзүүлэх хор хохирол өндөртэй гэмт хэрэг юм.



Гэтэл энэхүү сөрөг үр дагавартай гэмт хэрэгтэй тэмцэж чадаагүйн улмаас ФАТФ-н саарал жагсаалтад орж эдийн засгийн хувьд зарим арга хэмжээнд хориг тавиулах нь манайх шиг хөгжиж буй улс орны эдийн засагт давхар цохилт болно.

**Мөнгө угаах, терроризмыг  
санхүүжүүлэхтэй тэмцэх  
тухай хууль**



**Монгол Улсын  
Эрүүгийн хууль**

<p><b>2002.01.13</b> <b>163 дугаар зүйл.</b></p>	<p><b>2008.02.01</b> <b>268<sup>1</sup> дүгээр зүйл.</b></p>	<p><b>2009.12.24</b> <b>166<sup>1</sup> дүгээр зүйл.</b></p>	<p><b>2014.01.16</b> <b>166<sup>1</sup> дүгээр зүйл.</b></p>	<p><b>2015.12.03</b> <b>18.6 дугаар зүйл</b></p>
<p>Илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан үйлдэл.</p>	<p>Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах, эсхүл хуурамч мөнгө тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого.</p>	<p>Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийн хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан шилжүүлсэн, хувиргасан үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцсон.</p>	<p>Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан эсхүл үүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан үйлдэл.</p>	<p>Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан үйлдэл</p>

# Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль



2006 оны 07 сарын 08-ны өдөр баталсан бөгөөд 2013 оны 05 сарын 31-ний өдөр Улсын Их Хурлаас тус хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Тус хуулийн гол **зорилт нь** мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд энэхүү ажиллагааг хэрэгжүүлэх үндэс суурь нь хуулиар мэдээллэх үүрэг хүлээсэн этгээдүүд 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр, тооцооны гүйлгээний тухай мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээллэх явдал юм.

Энэхүү хуулийн **гол цөм нь** Санхүүгийн мэдээллийн алба юм.

**Санхүүгийн мэдээллийн алба нь** дээрх мэдээллэх үүрэгтэй этгээдүүдээс мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага юм.

МУТСТтХууль нь мөнгө угаах гэмт хэргийг цогцоор нь шийдвэрлэх үндсэн хэм хэмжээ чиг баримжаа болох ёстой. Энэхүү хуулийг тулгуурлан Эрүүгийн хууль болон бусад бодлого журамд тус гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг нарийвчлан зохицуулах ёстой. Гэтэл энэхүү хуулинд зөвхөн тус гэмт хэргийн урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон тус ажиллагааг хэрэгжүүлэгч санхүүгийн мэдээллийн албаны чиг үүргийг гол төлөв хуульчилсан нь учир дутагдалтай байна.

Аливаа гэмт хэргийг цогц байдлаар шийдвэрлэхийн тулд дараах ажиллагаануудыг хэрэгжүүлэх ёстой.

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
2. Гэмт хэргийг илрүүлэх
3. Гэмт хэргийг таслан зогсоох
4. Гэмт хэрэг үйлдсэн хүнд оновчтой хариуцлага хүлээлгэх

Өөрөөр хэлбэл МУТСТтХ нь зөвхөн тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд санхүүгийн мэдээллийн албаны оролцох оролцоо бус мөнгө угаах гэмт хэргийг цогц байдлаар шийдвэрлэхэд туслах дээрх арга замуудыг багтаан хуульчлах нь зохистой байна.




**Мөнгө угаах гэмт  
хэргийг хянан  
шийдвэрлэсэн  
шүүхийн практик,  
статистик**



## Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн практик, статистик

Монгол Улсын Шүүхийн цахим санд буй 2020 оноос 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаан дах мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилсэн 148 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ.

Практикт шүүх мөнгө угаах гэмт хэрийг шийдвэрлэхдээ суурь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг мөнгө угаах гэмт хэрэгт ихэнх тохиолдолд гэм буруутайд тооцож шийдвэрлэсэн нь тоон үзүүлэлтүүдээс харагдаж байна. Үүнийг суурь гэмт хэргээр нь задалж харвал:



ЭХ-ийн 18.6.1 дэх хэсэгтэй давхар зүйлчлэн хянан шийдвэрлэсэн хэрэг





## Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийлвэрлэсэн шүүхийн практик, статистик

### Суурь гэмт хэргийн төрөл

Эрүүгийн хуулийн зүйл	2020 он	2021 он	2022 он	2023 он 4-р сар	Нийт	Эзлэх хувь
11.6 Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	3	-	2	1	6	3.2
13.5 Заналхийлэх	-	-	-	1	1	0.53
17.1 Хулгайлах	18	19	18	7	62	33.15
17.2 Дээрэмдэх	16	2	6	1	25	13.36
17.3 Залилах	2	2	3	4	11	5.88
17.4 Хөрөнгө завших	4	2	3	-	9	4.8
17.5 Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, алдуул мал завших	9	4	4	2	19	10.16
17.12 Мал хулгайлах	14	6	12	3	35	18.7
20.3 Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх	-	1	1	-	2	1.06
20.7 Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	1	-	-	-	1	0.53

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээнд

- албан тушаал, эрх мэдлийн байдлаа урвуулан ашиглах,
- хахууль авах,
- татвар төлөхөөс зайлсхийх,
- цахим мэдээлэлд хууль бусаар халдах зэрэг гэмт хэргүүдээс мөнгө угаагдах өндөр эрсдэлтэй гэж үзсэн.



Гэвч өмнөх хүснэгтээс харвал шийдвэрлэж буй мөнгө угаах гэмт хэргийн шүүхийн шийдвэрт дийлэнх суурь гэмт хэрэг нь хохирол багатай ахуйн хүрээнд үйлдэгддэг **хулгайлах, дээрэмдэх, залилах, мал хулгайлах, эд хөрөнгө завших гэмт хэргүүд** байна. Хулгайлах, дээрэмдэх, завших зэрэг гэмт хэргүүд нь мөнгө угаах гэмт хэргийн үе шатуудыг хангахгүй, шууд үйлдэгддэг тул мөнгө угаах гэмт хэргийг ахуйн хүрээний нэг үйлдэлтэй гэмт хэргээс ялгах шаардлагатай гэж үзэж байна.




2002 оны  
Эрүүгийн хуулийн  
тусгай ангийн 155  
дугаар зүйлд  
заасан “Гэмт хэрэг  
үйлдэж олсон эд  
хөрөнгө борлуулах”  
гэмт хэрэг

Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, хадгалсан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

**Мөнгө угаах гэмт хэргийн эрх  
зүйн зохицуулалтыг  
боловсронгуй болгох нь**

**“Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ын 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа урт байх, хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт этгээдийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гарахаас зайлсхийх нөхцөл болохгүй байх талаар тусгасан.**



**НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах алба ба**

Олон улсын валютын сангийн хувьд мөнгө угаах үндсэн гэмт хэрэгт хэрэглэх хөөн хэлэлцэх хугацаа 12-15 жил байвал зохимжтой талаар тэмдэглэсэн.

*МУ-н Эрүүгийн хууль дахь мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны өөрчлөлт*

	<b>2002.01.03 163 дугаар зүйл</b>	<b>2008.02.01 268<sup>1</sup> дүгээр зүйл</b>	<b>2009.12.24 166<sup>1</sup> дүгээр зүйл</b>	<b>2014.01.16 166<sup>1</sup> дүгээр зүйл</b>	<b>2015.12.03 18.6 дугаар зүйл</b>
Үндсэн гэмт хэрэг	5 жил	5 жил	5 жил	5 жил	1 жил
Хүндрүүлэх нөхцөлд	15 жил	15 жил	15 жил	15 жил	5 жил
Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	25 жил	25 жил	15 жил	15 жил	12 жил

*Гадаад орон дахь мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа*

<b>Дд</b>	<b>Улсын нэр</b>	<b>Хөөн хэлэлцэх хугацаатай эсэх</b>	<b>Хугацаа</b>
1	Канад	Үгүй	-
2	ИБУИНВУ	Үгүй	-
3	Итали	Тийм	15 жил
4	ХБНГУ	Тийм	20 жил

## **Мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа**

Мөнгө угаах гэмт хэрэг нь олон үе шаттай, үндэстэн дамнаж явагддаг илрүүлэхэд нэн төвөгтэй байдаг. Тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа багаас болж мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, гэмт хэрэг гарах эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай юм.

Иймд энэхүү гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тус гэмт хэргийн шинж чанар, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албаны зөвлөмж, улс орнуудыг жишигт уялдуулан үндсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 12 болон түүнээс дээш жилээр нэмэгдүүлэх шаардлагатай байна.



# Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг

ФАТФ-ын зөвлөмжийн 3-д:

“Улс орнууд мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг хамруулж, өргөн хүрээний суурь гэмт хэргийг хамруулбал зохино. Суурь гэмт хэрэгт:


- бүх гэмт үйлдлийг хамруулах,
- эсхүл тухайн суурь гэмт хэрэгт оногдуулж буй хорих ялын хэмжээнээс хамаарч,
- эсхүл суурь гэмт хэрэгт тооцох гэмт хэргүүдийн жагсаалтыг гарган
- эсвэл эдгээр аргуудыг хослуулан холимог аргачлалаар хамруулж болно.” гэж зохицуулсан байдаг.

2003 оны НҮБ-ын “Авлигын эсрэг конвенц”-н хүрээнд 2 дугаар зүйлийн 2.н-д “Суурь гэмт хэрэг гэдэг нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 23 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргийн зүйл болж болох орлогыг бий болгосон гэмт хэргийг хэлнэ” гэж заасан.

ФАТФ-ын зөвлөмжид зааснаар суурь гэмт хэрэг гэдэгт онц ноцтой ямар ч гэмт хэрэг хамаарах хэдий ч ихэнхдээ зохион байгуулалттай гэмт хэргүүд багтдаг.

Монгол улсын хувьд “Мөнгө угаах” гэмт хэргийг анх 2002 оны 01 сарын 03-ны өдөр батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангиар зохицуулсан.





Монгол улсын Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 1-т “**Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж...**” гэж мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тусгасан.



Монгол улсын ЭХ-ийн тусгай ангид заасан бүх гэмт хэргийг үйлдэж, тэдгээр гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгийг эзэмшсэн, ашигласан, захиран зарцуулсан бол мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн гэж үзэхээр байна.

Үүнээс харахад манай улс мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг анх Эрүүгийн хуулийн 2008 оны 02 сарын 01-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр нарийвчлан зохицуулсан хэдий ч суурь гэмт хэргүүдийг тодорхой төрлийн гэмт хэргээр хязгаарлаж, хязгаарлагдмал хүрээнд авч үзсэн нь зарим төрлийн гэмт хэргийг орхигдуулан нөгөө талаар эрх зүйн хийдэл үүсгэж байжээ.

*МУЭХ-д заасан мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт орсон нэмэлт өөрчлөлтүүд*

	<b>2008.02.01</b> 268 <sup>1</sup> дүгээр зүйл	<b>2009.12.24</b> 166 <sup>1</sup> дүгээр зүйл.	<b>2014.01.16</b> 166 <sup>1</sup> дүгээр зүйл.	<b>2015.12.03</b> 18.6 дугаар зүйл
Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг	Зэвсэг, хар тамхи, хүн худалдаала х, хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон...	Суурь гэмт хэргийг тодорхой нэрлээгүй.	Суурь гэмт хэргийг тодорхой нэрлээгүй.	Суурь гэмт хэргийг тодорхой нэрлээгүй.

# Эрүүгийн хариуцлага

## Америкийн нэгдсэн улс:

- 500,000 доллар хүртэл эсхүл хууль бус орлогыг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль төлөх
- 20 жил хүртэл хугацаагаар шоронд хорих

## Англи:

- 14 жил хүртэл хугацаагаар хорих
- Торгох ял
- Эсвэл хоёуланг нь оногдуулах

## Япон:

- 5 жил хүртэл хугацаагаар хорих ял
- 3 сая хүртэл иенээр торгох
- Эсвэл хоёуланг нь оногдуулах
- Хэрэв энэ гэмт хэргийг үйлдэхээр завдсан бол 2 жилээр хорих, эсхүл 500 мянган иенээр торгох

	Үндсэн гэмт хэрэг	Хүндрүүлэх нөхцөлд	Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	Хуулийн этгээд үйлдсэн
<b>2015.12.03</b> 18.6 дугаар зүйл	<b>6 сар-1 жил</b> зорих эрхийг хязгаарлах <b>6 сар-1 жил</b> хорих ял	<b>1-5 жил</b> зорчих эрхийг хязгаарлах <b>1-5 жил</b> хорих ял	<b>5-12 жил</b> хорих ял	Хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасах <b>120,000-400,000 мянган нэгжтэй</b> тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял

□ Мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албанаас зөвлөсөн тус гэмт хэрэгт хэрэглэвэл зохимжтой хөөн хэлэлцэх хугацаанаас 11-14 жилээр бага байгаа нь “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ын 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа урт байх гэсэн заалтад нийцэхгүй байна. Иймд олон улсын жишгийн дагуу Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан тус гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

□ МУТСТ-Хууль нь мөнгө угаах гэмт хэргийг цогцоор нь шийдвэрлэх тусгай хэм хэмжээ чиг баримжаа болох ёстой. Энэхүү хуулийг тулгуурлан Эрүүгийн хууль болон бусад бодлого журамд тус гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг нарийвчлан зохицуулах ёстой. Гэтэл энэхүү хуулинд зөвхөн тус гэмт хэргийн урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болон тус ажиллагааг хэрэгжүүлэгч санхүүгийн мэдээллийн албаны чиг үүргийг гол төлөв хуульчилсан нь учир дутагдалтай байна.



## Дүгнэлт, санал

❑ Манай улс нийгмийн хор аюул ихтэй, хар тамхи, байгаль орчны эсрэг гэмт хэргүүд, хүн худалдаалах, мансууруулах бодисын худалдаа гэх мэт гэмт хэргүүдийг илрүүлж, түүнээс олсон хөрөнгө мөнгийг угааж буй эсэхийг олж тогтоож, оновчтой шийдвэрлэж чадахгүй байгаа нь харагдаж байна. Тиймээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт тооцох гэмт хэргүүдийг тоочин нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

❑ Монгол улсын шүүхийн практикт мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэсэн шийдвэрүүдээс харахад дийлэнх хувь нь ахуйн хүрээнд үйлдэгддэг гэмт хэргийг суурь гэмт хэрэгт тооцож шийдвэрлэжээ. Тэдгээр ахуйн хүрээнд үйлдэгдэж буй хулгай, дээрэм, залилан гэх мэт гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгийг ашиглаж, эзэмшиж, захиран зарцуулвал гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө борлуулах, авах гэмт хэрэг хэмээх зүйлээр зүйлчлэх нь зохистой байх тул Эрүүгийн хуульд **“Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө борлуулах, авах”** хэмээх гэмт хэргийг нэмэх санал дэвшүүллээ.



## Дүгнэлт, санал

Анхаарал хандуулсанд  
баярлалаа.

